



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 7/16


Улаанбаатар хот

“Ажил танилцуулах, туршлага солилцох” өдөр” зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооноос дүүргийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран “Ажил танилцуулах, туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулсугай.
2. “Ажил танилцуулах, туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулах хуваарийг хавсралтаар баталсугай.
3. Дээрх ажлыг тогтмол зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн Г. Бямбасайханд даалгасугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500053

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дугаар тушаалын хавсралт



Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хороо, спорт хороодын хамт “ажил танилцуулах, туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулах хуваарь

№	Сарууд	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
1	Нийслэлийн БТСГ			X	X	X	X			X	X	X	
2	БГД				X								
3	БЗД						X						
4	БНД										X		
5	БХД						X						
6	СХД									X			
7	СБД									X			
8	ХУД											X	
9	ЧД					X							
10	НД					X							

Тавигдах шаардлага:

1. Дүүргийн Биеийн тамир, спортын хороод “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийг нийслэлийн Биеийн тамир, спортын хорооноос батлагдсан хуваарийн дагуу тушаал, хөтөлбөр, төлөвлөгөө гарган чанарын өндөр түвшинд зохион байгуулж зурагжуулсан тайлан, бусад холбогдох материалуудыг
2. Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороонд 3 хоногт багтаан цахимаар болон албан тоотоор ирүүлнэ.
3. “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулах байршлыг дүүргийн Биеийн тамир, спорт хороод өөрсдөө тогтооно. “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийг тухайн дүүргийн Биеийн тамир, спорт хороо зохион байгуулахдаа Биеийн тамир, спорт хороонууд, Спортын холбоод, Спортын клубууд, Эрүүл мэндийн нэгдэл, ТББ, болон бусад аж ахуй нэгж байгууллагуудын хамтлагуудыг оролцуулж хамтран ажиллаж өргөн олныг хамруулна.

4. Өмнөх онуудад дүүргүүдийн БТСХ-оос зохион байгуулсан “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийн гол гол шинэлэг санаа, үр дүнд хүрсэн ажлуудыг туршлага болгон нэвтрүүлсэн байна.

5. Дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлж байгаа онцлог, шинэлэг санаа, үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг олон нийтэд зурагт үзүүлэн, самбар, презентэйшн, бусад боломжтой нөхцлөөр сурталчилан таниулна.

6. Байгууллагын болон биеийн тамир, спорт, чийрэгжилтийн үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагаатай холбоотой санал асуулга авч нэгтгэн дүгнэж үнэлэлт дүгнэлт өгч хэрэгжүүлэх санал боловсруулж үйл ажиллагаандаа тусгаж ажиллана.

7. Телевиз, сонин, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлаж хамтарч ажилласан байна.

8. Тухайн дүүргийн Биеийн тамир, спорт хороо нь бусад дүүргийн Биеийн тамир, спорт хороодоос зохион байгуулж байгаа “Ажил танилцуулах, туршлага солилцох өдөр”-т заавал төлөөлөл оролцуулна.

Тухайн биеийн тамир, спорт хорооноос зохион байгуулсан “Ажил танилцуулах, туршлага солилцох өдөр”-ийн нийт үнэлгээг 2018 оны байгууллагын ажил дүгнэх журамд оруулан тооцно.

Шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх хүснэгт

№	Үзүүлэлтүүд	Үнэлгээ /авах оноо/
1.	Тушаал, хөтөлбөр, төлөвлөгөөгөө гарган зохион байгуулж, тайлан мэдээг цаг хугацаанд нь ирүүлсэн байна.	0-2
2.	Биеийн тамир, спортын хороод, спортын холбоод, спортын клубүүд, эрүүл мэндийн нэгдэл, ТББ, болон бусад аж ахуй нэгж байгууллагуудын хамтлагуудыг оролцуулж хамтран ажиллаж өргөн олныг хамруулсан байна.	0-15
3.	Байгууллагын болон биеийн тамир, спорт, чийрэгжилтийн үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагаатай холбоотой санал асуулга авч нэгтгэн дүгнэж, үнэлэлт, дүгнэлт өгч, хэрэгжүүлэх, санал боловсруулж үйл ажиллагаандаа тусгаж ажиллана.	0-10
4.	Гарын авалга, тараах материал болон бусад боломжит хувилбарууд болон мэдээллийн хэрэгслээр сурталчлаж хамтарч ажилласан байна.	0-15
5.	Тухайн дүүргийн Биеийн тамир, спорт хороо нь бусад дүүргийн Биеийн тамир, спорт хороодоос зохион байгуулж байгаа “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-т заавал төлөөлөл оролцуулна.	0-8
Нийт үгнэлгээ:		0-50

Шинэлэг, үр дүнтэй санаачлага гарган хэрэгжүүлсэн ажилд 5 хүртэл оноог нэмэлтээр олгоно.

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО